



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А-206

Улаанбаатар хот

Техник хүлээн авах ажлын хэсэг  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2021 онд Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын зээлийн эх үүсвэрээр худалдан авч байгаа газар тариалангийн зориулалттай трактор, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Үнэнбат,

Гишүүд:

- Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Д.Баярсайхан,
- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн А.Бямбадорж,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Г.Мөнхмаргад,
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Э.Өнө-Ундрах,
- Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Г.Ганбат

Нарийн бичгийн дарга:

- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн М.Ариунболд

2. Гэрээгээр нийлүүлж байгаа трактор, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмжийг гэрээ, хэлэлцээрийн баримт бичигт тусгасан тоо, техникийн тодорхойлолтын үзүүлэлтийн дагуу тус бүрт нь нягтлан тулгаж, бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авч дүгнэлтийг танилцуулж ажиллахыг ажлын хэсэг /В.Үнэнбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000822